

“GO MONGOLIA” ГҮҮРНИЙ ШИЛДЭГ САНАА, ДИЗАЙН ШАЛГАРУУЛАХ УРАЛДААНЫ УДИРДАМЖ

2024 оны 05 сарын 15

Улаанбаатар хот

НЭГ. АГУУЛГА

1.1. ЗОРИЛГО

Монгол Улсын Засгийн газар “20 минутын хот” шинэчлэлийн хүрээнд нийслэл Улаанбаатар хотын Бага тойруугаас Хөшигийн хөндийн “Чингис хаан” олон улсын нисэх онгоцны буудал хүртэл “Хос цамхагт тулгуурт дүүжин гүүр-туннел-авто замын байгууламж” барихаар шийдвэрлэсэн.

Том хэмжээний гүүрэн байгууламж нь тухайн улс үндэстний өнгө төрх, нүүр царайг илэрхийлдэг учир “Өөдөө тэмүүлэх Монгол” буюу “Go Mongolia” хэмээн нэрлэхээр тогтсон.

Монгол Улсыг дэлхий дахинд илэрхийлж буй “Go Mongolia” түлхүүр үгийн утга санааг тод томруун илэрхийлсэн, шинэ брэнд, өнгө төрхтэй байх нь зүйтэй гэж үзэж, олон улсын болон дотоодын инженер, архитекторуудын дунд шилдэг санаа, шийдэл, архитектур, дизайныг шалгаруулах уралдааныг зарлаж байна.

Эрхэм уран бүтээлчид Та бүхнийг өргөнөөр оролцохыг урьж байна.

1.2. УРАЛДААНД ОРОЛЦОГЧДЫН ХАМРАХ ХҮРЭЭ

- Зураг төслийн байгууллага;
- Архитектор, инженер, мэргэжлийн уран бүтээлчид.

1.3. МАТЕРИАЛЫН БҮРДЭЛД ТАВИГДАХ ШААРДЛАГА

- 1.3.1. Тайлбар бичиг /концепц/ (Эцсийн файл: .pptx, .pdf;)
- 1.3.2. Зураглалын материал (Эцсийн файл: .jpg, .pdf;)
- 1.3.3. Видео танилцуулга (5 минут .mp4, 1080HD, болон түүнээс дээш;)
- 1.3.4. Бусад танилцуулга (Төрөл хэмжээ нээлттэй)
- 1.3.5. Оролцогч баг болон байгууллага өмнө нь хийж гүйцэтгэсэн ижил төстэй зураг төслийн ажлын талаарх мэдээлэл.

1.4. БАЙРШИЛ

Монгол улс, Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Үндэсний цэцэрлэгт хүрээлэнгээс “Хүрхрээгийн ам” хүртэл (Богдхаан уулын Бага тэнгэр ам, Залаатын амын хоорондох богино ам) баригдах авто замын трассын дагуу Туул гол дээгүүр баригдана.

1.5. ЗОХИОГЧИЙН ЭРХ

- Шилдгээр шалгарсан бүтээлүүдийн зохиогчийн эрх нь уралдаан зарласан захиалагч байгууллагын талд үлдэх ба цаашид ашиглах, хөгжүүлэх онцгой эрх захиалагч байгууллагад хадгалагдана.
- Уралдаанд ирүүлсэн бүтээлүүдийг буцааж олгохгүй бөгөөд захиалагч байгууллагад үлдэнэ.

- Шилдэг санаа, шийдэл боловсруулсан оролцогч ажлын зураг төсөл боловсруулах давуу эрхтэй оролцоно.

1.6. МАТЕРИАЛ ИРҮҮЛЭХ ХУГАЦАА, ХҮЛЭЭН АВАХ ХАЯГ

2024 оны 05-р сарын 17-ны өдрөөс 2024 оны 05-р сарын 31-ний өдрийн 17.00 цаг хүртэл цахим хэлбэрээр info@moc.gov.mn, цаасан хувилбараар Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 7-р хороо, Денверийн гудамж, Монгол Улсын Соёлын яамны 103 тоотод хүлээн авна.

ХОЁР. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, ШАГНАЛ, УРАМШУУЛАЛ

2.1. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Соёлын сайдын тушаалаар батлагдсан уралдааныг дүгнэх үүрэг бүхий шүүгчдийн бүрэлдэхүүн дараах шалгуур үзүүлэлтийн дагуу дүгнэнэ.

№	Шалгуур үзүүлэлт	Нийт оноо: 100
1	Ажлын даалгаврын шаардлагад нийцсэн байдал	70
2	Баримт бичгийн бүрдэл, техникийн гүйцэтгэл	20
3	Байгаль орчинд ээлтэй, эрчим хүчний хэмнэлттэй шинэ технологийн шийдэл тусгасан байдал	5
4	Оролцогч баг болон байгууллага өмнө нь хийж гүйцэтгэсэн ижил төстэй зураг төслийн байдал	5

2.2. ШАГНАЛЫН САН, ШАГНАЛ УРАМШУУЛАЛ

1-р байр: 100'000'000₮ /нэг зуун сая төгрөг/;

2-р байр: 60'000'000₮ /жаран сая төгрөг/;

3-р байр: 40'000'000₮ /дөчин сая төгрөг/.

Дэлгэрэнгүй мэдээллийг доорх хаягаар тодруулна уу.

Соёлын яамны Урлаг, уран бүтээлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар Хаяг: Сүхбаатар дүүрэг, 7-р хороо, Денверийн гудамж -103 тоот Утас: (51)-265636/ 99106818	Хөшигийн хөндийн бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргаа Хаяг: Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Хангарьд ордон, 901 тоот Утас: (51)-267448 / 267449
---	--

Жич: “Go Mongolia” гүүрний техникийн тодорхойлолт, холбогдох мэдээллийг хавсаргав.

“GO MONGOLIA” ГҮҮРНИЙ ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ



Нэр	Go Mongolia
Гүүрний төрөл	Хос цамхагт дүүжин гүүр
Урт	900 м
Авто замын урсгал	2 урсгал
Авто замын эгнээ	6 эгнээ
Гатлах төрөл	Туул гол дээгүүр
Авто замын төрөл	Хурдны зам

“GO MONGOLIA” ГҮҮРНИЙ АЖЛЫН ДААЛГАВАР

Уралдаан зарлах үндэслэл	<ul style="list-style-type: none">- Монгол Улсын Их хурлын 2024 оны “Төрийн байгууллагуудыг бүсчлэн байршуулах тухай” 12 дугаар тогтоол,- Монгол Улсын Засгийн газрын 2022 оны “Төрийн захиргааны зарим байгууллагыг Хөшигийн хөндий рүү нүүлгэн шилжүүлэх арга хэмжээний тухай” 98 дугаар тогтоол- Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн хуралдааны 12 дугаар тэмдэглэл- Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн хуралдааны 17 дугаар тэмдэглэл
Байршил	<p>Их Монгол Улсын гудамж “Хан-Уулын И-Март”-ын уулзвараас Үндэсний цэцэрлэгт хүрээлэнгийн урдуур гарч Богдхан уулын Хүрхрээгийн ам хүртэлх төлөвлөж буй авто замын трассын дагуу Туул гол дээгүүр баригдах 6 эгнээтэй хоёр урсгалтай 900 м урттай хос цамхагт тулгуурт дүүжин гүүр</p> <p>DWG файлыг эндээс татаж авна уу.</p>
Агуулга	<p>Монгол Улсыг олон улсад илэрхийлж буй “Өөдөө тэмүүлэх Монгол” буюу “GO MONGOLIA” түлхүүр үгийн утга санааг илэрхийлсэн Монгол үндэсний хэв шинж, шинэ өнгө төрхийг олон улсад илэрхийлэх шилдэг санаа, дизайнтай байх</p> <p><u>MONGOLIA (guidebookgomongolia.mn)</u></p>
Хамрах хүрээ, газар нутаг	<ul style="list-style-type: none">- Төлөвлөж буй өндрийн схем зураг татаж авах. <u>Төлөвлөж буй өндрийн схем зураг.jpg - Google Drive</u>- Замын трассын зураг DWG татаж авах <u>Замын трасс.dwg - Google Drive</u>